

**“БОГД БАНК ХК-ЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН ЭРДЭНЭ ОВОГТОЙ БЯМБАЖАВЫН 2022 ОНЫ 4-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”****Нэг. ТУЗ-ийн гишүүн.**

- 1.1 “Богд банк” ХК-ий ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ТУЗ-ийн 2022.07.06-ны А-1/779 тоот тогтоолоор миний бие сонгогдон “Богд банк” ХК-тай 2022.09.19-нд гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ хугацаанд цахимаар болон биеэр ТУЗ-ийн 27 удаагийн хуралд оролцон хэлэлцсэн бүх асуудлаар саналаа хэлж, хурлын тэмдэглэл болон шийдвэрт тусгуулан ажиллав.
- 1.2 ТУЗ-ийн хурлаас миний биеийг ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороодын даргаар томилсон.  
Энэ 2 хорооны ажилд нэлээд цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулах шаардлагатай байв.

**Хоёр. Аудитын хороо.**

- 2.1 Аудитын хороо нь Богд банк, түүний Дотоод аудитын газартай нэлээд нягт ажиллах, Богд банкны зорилтоо хэрэгжүүлэхэд нь ДАГ-ын үүрэг роль, ач тус, зөвлөмж, дэмжлэгийг нэмэгдүүлэх нь чухал гэдэг зарчмыг баримталдаг.  
Дотоод аудит нь системтэй, стандарт, шалгуурт нийцсэн аргачлал ашиглаж, банкныхаа эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын тогтолцоог үнэлж сайжруулах замаар банк зорилгодоо хүрэхэд туслаж байх нь нэн чухал. ДАГ-ын аудитын үйл ажиллагаа нь хараат бус, бодитой баталгаажуулалт болон зөвлөх үйлчилгээ байх шаардлагатай Банкны нийт үйл ажиллагаа, ялангуяа зээлийн олголт, ашиглалт, төлөлтийг эрсдэлд суурьласан баталгаажуулалтаар хангах нь нэн чухал.
- 2.2 ДАГ нь 2022 онд 40 аудитын ажил төлөвлөснөөс эргэн хяналтын 4 аудитыг дараа оны эхний улиралд хийхээр хойшлуулж, 34 аудитыг гүйцэтгэсэн байна. ДАГ нь 4 ажилтантайгаар аудитыг гүйцэтгэснээс аудитор М.Зандан нь олон улсад зөвшөөрөгдсөн “Мэргэшсэн дотоод аудитор” цол авсан бол ерөнхий аудитор Д.Төрмандах ММНБИ-ийн Хөндлөнгийн аудиторын батламж авсан зэргийг АХ сайшаан тэмдэглэж байна. ДАГ нь дотоод аудитын тэргүүн туршлагыг ашиглан чадварлаг аудитруудаар аудитаа гүйцэтгэн банкны бүхий л үйл ажиллагааг нь үр өгөөжтэй, хяналттай байлгахад чиглэсэн үнэ цэнэтэй үйлчилгээг үзүүлэх эрхэм зорилт дэвшүүлэн ажиллаж, Богд банкны болон ДАГ-ын жилийн ажлын тайлан, дүнгээс үзэхэд “дээрх зорилтоо үндсэнд нь ханган ажилласан байна” гэж дүгнэж байна.
- 2.3 Зээлийн олголт, ашиглалттай холбоотой зөрчил аудитаар илэрсэнийг засч арилгах, зээлийн олголт, ашиглалт, төлөлтийн хяналтыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллажээ. Тэрчлэн банкны хэмжээнд мэдээллийн хөрөнгийн бүртгэлтэй болох, мэдээллийн эзэмшигчийг тодорхойлох, энэ процессыг зохицуулах бодлого, журамтай болох, банкны бизнесийн зорилгод нийцсэн дата менежментийн стратеги боловсруулах, data quality plan-өгөгдлийн чанарыг сайжруулах төлөвлөгөөтэй болох зэрэг санал, зөвлөмжийг ДАГ-аас дэвшүүлснийг АХ дэмжиж, Богд банкны гүйцэтгэх удирдлагын анхааралд хүргэж байна.
- 2.4 Аудитын хороо нь 2022.11.23-нд хурал (сүүлчийн хурал) хийж дараах асуудал хэлэлцсэн.
1. ДАГ-ын үйл ажиллагаа, төлөвлөгөөний биелэлт, өгөх дүгнэлт.
  2. АХ-д гишүүн нэмэх тухай.
  3. Чанарын баталгаажуулалтын тайлан, анхаарах асуудал.
  4. “Дотоод аудитын бодлого”-ын төсөл.
- Хурлаас гарсан шийдвэр:

**“БОГД БАНК ХК-ЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН ЭРДЭНЭ ОВОГТОЙ БЯМБАЖАВЫН 2022 ОНЫ 4-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”**

- 2.4.1 Энэхүү тайланд дээр дурьдсанаар ДАГ нь 2022 онд 34 аудитын ажлыг гүйцэтгэж, Богд банкны ажлыг улам сайжруулах, зээл олголт, ашиглалт, төлөлтийн хяналтыг нэмэгдүүлэх, аудитаар илэрсэн ажлын зарим доголдол, дутагдал, зөрчлийг арилгах талаар зохих зөвлөмж, санал өгч ажилласныг тэмдэглэж, төлөвлөгөөт ажлаа гүйцэтгэх, Богд банкны гүйцэтгэх удирдлагад өгөх зөвлөмж, үнэлгээ, баталгаажуулалтаа нэгтгэн дүгнэж тайлангаа гаргах үүргийг ДАГ-т өгөөд байна.
- 2.4.2 ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооны гишүүнээр Д. Моломжамцыг сонгох саналыг АХ-ы бүх гишүүд санал нэгтгэйгээр дэмжиж ТУЗ-ийн шийдвэр гаргуулахаар тогтов.
- 2.4.3 “Дотоод аудитын бодлого”-ын төслийг гишүүдээс гаргасан саналыг тусган дахин боловсруулахыг ДАГ-т даатгасан.

**Гурав. Эрсдэлийн удирдлагын хороо.**

- 3.1 Богд банк нь ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ-оос гадна ГЗ-ын дэргэдэх эрсдэлийн удирдлагын газартай, тэр нь 5 хэлтэстэйгээр банкны эрсдэлийн удирдлагын үндсэн функцуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Банкны гүйцэтгэх удирдлагын дэргэдэх ЭУХ нь 2022 онд 34 удаагийн хурлаар 81 асуудлыг хэлэлцэн зохих арга хэмжээ авч ажилласан байна. Банкны гүйцэтгэх удирдлага, эрсдэлийн удирдлагын газар (ЭУГ), түүний хэлтсүүдээс хийсэн аудит, зөвлөмж, үнэлгээг үндэслэн ажлаа улам сайжруулах арга хэмжээг зохих төлөвлөгөө, удирдамж чиглэл, үнэлгээ, баталгаажуулалт, зөвлөмжийн дагуу аван ажиллаж байна.
- 3.2 Тус газар нь эрсдэлийн аппетитыг ТУЗ-аас баталсан 5 бүлэг, 9 асуудлаар тооцож ажилладаг бөгөөд зээлийн ангилалын хяналтыг улирал дутам гүйцэтгэдэг. Чанаргүй зээлийн хэмжээ, анхаарал хандуулах зээлийг түлхүү анхаарч, сар, улирал дутам явц, үр дүнг авч хэлэлцэн шаардлагатай арга хэмжээг авах нь чухал. ЗГ-ийн дэргэдэх эрсдэлийн хороо нь өөрийн хөрөнгө, активын өгөөж, нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ зэргийн хяналтыг гүйцэтгэж, тухайн үеийн зорилгод тавьсан хувь хэмжээнээс хэтрүүлэхгүй байхыг илүү анхаарч байна.
- 3.3 ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо нь (ЭУХ) 2022 оны 11-р сарын 02-ны өдөр хуралдаж (сүүлийн хурал), дараах асуудлыг авч хэлэлцэн зохих шийдвэр гаргасан:
  - 1. Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, цаашдын зорилт.
  - 2. Эрсдэлийн аппетитын явц, гүйцэтгэл.
  - 3. Зээлийн багцын тайлан, анхаарах асуудал.
  - 4. Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого, нэмэлт, өөрчлөлт, ТУЗ-аар батлуулах шаардлага.
- 3.4 ТУЗ-ийн АХ-ны шийдвэр:
  - 3.4.1 Одоогийн (оны эхний 10 сарын) гүйцэтгэлийг улам сайжруулан 2022 онд төлөвлөсөн ажлаа бүрэн хэрэгжүүлж, жилийн ажлаа он гарангуйт дүгнүүлэхийг ЭУГ-т даалгасан.
  - 3.4.2 Эрсдэлийн аппетитын үзүүлэлтийг чанд мөрдөж, зээлийн ангиллыг хэвийн болгох, эрсдэлийн сангийн зардлыг бууруулах, оны эцэст аппетитын бүх үзүүлэлтийг бүрэн ханган давуулан биелүүлэхийг ЭУГ, банкны бусад салбар нэгжид даалгавар болгосон.
  - 3.4.3 Сар дутмын эрсдэлийн хяналтын үзүүлэлтүүдийг нэгтгэн гаргах, дүгнэхэд илүү хялбар болгох, энэ талаар Моломжамц гишүүний саналыг үндэслэн олон улсын банкны туршлагыг судлан төсөл боловсруулахыг ЭУГ-т даалгасан.

**“БОГД БАНК ХК-ЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН  
ЭРДЭНЭ ОВОГТОЙ БЯМБАЖАВЫН 2022 ОНЫ 4-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”**

3.4.4 Байгаль орчин, нийгмийн хариуцлагын мөрдөж буй бодлогод оруулах нэмэлт өөрчлөлтийг дэмжиж, урьд нь ГЗ-ын тушаалаар батласан БО НХ-ын бодлогыг ТУЗ-ын шийдвэрээр батлуулахыг ГЗ-д даалгасан.

**Дөрөв. Дүгнэлт, санал.**

- 1.1 Богд банкны ажил жигдэрч, хувь нийлүүлэгчид, ТУЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэн хэвийн ажиллаж байгааг тэмдэглэж байна. ДАГ-аас болон ТУЗ, АХ-өөс өгсөн зөвлөмж, үнэлгээ, баталгаажуулалт, аудитын дүгнэлтийн мөрөөр холбогдох арга хэмжээг банкны гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлэн ажиллаж байна.
- 1.2 ТУЗ, АХ нь банкны гүйцэтгэх удирдлагаас болон ДАГ-аас тавьсан асуудал, санал, төслийг тухай бүр нь цахимаар болон биечлэн хэлэлцэж, зохих шийдвэр гарган гүйцэтгүүлж байна.
- 1.3 ДАГ нь аудитын дүгнэлт, үнэлгээ, баталгаажуулалт, зөвлөмжөө хараат бус байх зарчим дээр үндэслэлтэй гаргаж, банкны үйл ажиллагаанд эерэг нөлөөлөн ажиллажээ.
- 1.4 Богд банкны ашигт ажиллагаа сайжирч илүү өсөлттэй байгааг эрсдэлийн удирдлагаар дэмжиж, зээлийн олголт, ашиглалт, төлөлтөд ахиц гарч байна.
- 1.5 “Богд банк нь Компаний тухай хууль, Банкны тухай хууль, Монгол банкны холбогдох журам, дүрэм, банкныхаа дүрмийн дагуу банкны засаглалыг хэрэгжүүлэн ажлаа жилээс жилд сайжруулан хэвийн ажиллаж байна” гэж АХ үзэж байна.
- 1.6 Банкны ДАГ, ЭУГ-аас гаргасан санал, дүгнэлт, зөвлөмж, үнэлгээ, баталгаажуулалтыг тухай бүр нь авч хэлэлцэн шаардлагатай арга хэмжээг авч байхыг банкны гүйцэтгэх удирдлагад даалгаж байна.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн  
2023.01.11

Э.Бямбажав.